

## ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.08.27-08.31

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ:** Энэ долоо хоногт АНУ-ын голлох индексүүд их хэмжээний өсөлттэй хаагдлаа. Nasdaq индекс анх удаа 8,000 нэгж давж хаагдав. S&P 500 индексийн сагсанд багтдаг мэдээлэл технологийн салбарын компаниудын хувьцааны ханш өссөн бол санхүү болон харилцаа холбооны салбарт үйл ажиллагаагаа явуулдаг компаниудын хувьцааны ханш унажээ.

Энэ долоо хоногт хувьцаат компаниудын 2-р улирлын санхүүгийн тайлан гарч дууссан учраас хөрөнгийн зах зээлд улс төрийн тогтворгүй байдал түлхүү нөлөөлжээ. АНУ, Мексик хоорондын худалдааны гэрээгээ ахин шинэчлэх болсон талаар мэдээлэл гарч зах зээлийн индексүүдэд эерэг нөлөө үзүүлжээ. Тус хэлэлцээрт Канад улс оролцож магадгүй гэсэн мэдээлэл хувьцаануудын ханшийг улам өсгөсөн байна.

Шинжээчид "Amazon" компанийн хувьцааны ханшийг шинээр таамаглаж, мөн "Berkshire Hathaway" компани "Apple" компанийн хувьцааг нэмж худалдаж авснаар эдгээр компаниудын хувьцааны ханш өсчээ.

БНХАУ экспортоо тэлэх зорилгоор юанийн ханшийг доогуур түвшинд барьж байгаа явдалд АНУ-ын Ерөнхийлөгч тус улсын импортод ахин татвар ногдуулна хэмээн мэдэгдсэн.

10 жилийн хугацаатай АНУ-ын Засгийн газрын бондын өгөөж энэ долоо хоногт тогвортой байлаа.

**Европ:** "Brexit"-ийн хэлэлцээрт хүрэх эцсийн тов дахин хойшлогдсоноор Европын компаниудын хувьцааны ханш тогтвортой байлаа. Их Британи, Европын Холбоо "Brexit"-ийн хэлэлцээрт хүрэх эцсийн хугацааг ирэх аравдугаар сард гэж байсныг 11 дүгээр сар болгож, дахин хойшлуулсан талаар эх сурвалж мэдээллээ. "Brexit" хэлэлцээрийн тодорхойгүй байдал 2017 оноос эхлэн Европын компаниудын хувьцааны ханш буурахад нөлөөлжээ. Түүнчлэн, Итали улсын төсвийн бодлого, эдийн засгийн удаашрал, худалдааны маргаан зэрэг нь тус бүс нутгийн хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлсөөр байна.

Энэ долоо хоногийн сүүлчээр Шведийн кроны ханш оны эхэн үеэс ам.долларын эсрэг 11.7%-аар суларчээ. 9-р сард болох сонгууль болоод хасах үзүүлэлттэй бодлогын хүү ийнхүү тус улсын валютын ханшид сөргөөр нөлөөлжээ.

**Япон:** Японы компаниудын хувьцааны ханш өсөлттэй хаагдлаа. Иенийн ханш ам.долларын эсрэг 110.8 болов.

7-р сард Япон улсын жижиглэнгийн худалдаа 1.5%-аар өсжээ. Хувийн хэрэглээ нэмэгдэж байгаа нь инфляцийн түвшинг Японы төв банкны зорилтот 2%-ийн түвшинд хүргэх боломжтой талаар мэдээллээ. Нөгөө талаас Япон улсын ажилгүйдлийн түвшин хоёр сарын турш дараалан өсч, 7-р сард 2.5%-д хүрчээ.

**БНХАУ:** АНУ-ын Ерөнхийлөгч 9-р сарын 6-наас өмнө БНХАУ-ын 200 тэрбум ам.доллартай тэнцэх импортын бараа бүтээгдэхүүнд ахин татвар ногдуулна хэмээн мэдээлж, худалдааны маргааны асуудлыг даамжруулжээ.

**Эх сурвалж:** Reuters, Troweprice

### Олон улсын индексүүд

| Индекс      | Улс        | Хаалт     | Өөрчлөлт |
|-------------|------------|-----------|----------|
| MSE TOP 20  | Монгол     | 19,841.58 | 3.50% ▲  |
| Dow Jones   | АНУ        | 25,964.82 | 0.68% ▲  |
| S&P 500     | АНУ        | 2,901.52  | 0.93% ▲  |
| Nasdaq      | АНУ        | 8,109.54  | 2.06% ▲  |
| S&P/TSX     | Канад      | 16,262.88 | -0.57% ▼ |
| FTSE 100    | Их Британи | 7,432.42  | -1.91% ▼ |
| S&P/ASX 200 | Австрали   | 6,328.00  | 1.29% ▲  |
| Nikkei 225  | Япон       | 22,865.15 | 1.17% ▲  |
| Hang Seng   | Хонг Конг  | 27,888.55 | 0.78% ▲  |

### Бондын өгөөж

| Бонд                   | Валют | Купон | Үнэ    |
|------------------------|-------|-------|--------|
| Mongol 2024 (Хуралдай) | USD   | 8.7%  | 109.66 |
| Mongol 2023 (Гэрэгэ)   | USD   | 5.6%  | 96.87  |
| Mongol 2022 (Чингис)   | USD   | 5.1%  | 96.14  |
| Mongol 2021 (Мазаалай) | USD   | 10.8% | 113.23 |
| DBM' 23 (Самурай)      | JPY   | 1.5%  | 104.36 |
| TDBM' 2020             | USD   | 9.3%  | 105.98 |

### Зах зээлийн хүү

| Хүү          | Хаалт | Өөрчлөлт |
|--------------|-------|----------|
| Libor 1M     | 2.114 | 0.04 ▲   |
| Libor 3M     | 2.321 | 0.00 ▲   |
| Libor 6M     | 2.536 | 0.01 ▲   |
| Libor 1YR    | 2.840 | 0.02 ▲   |
| US 6M Bond   | 2.260 | 0.03 ▲   |
| US 2YR Bond  | 2.627 | 0.00 ▲   |
| US 3YR Bond  | 2.691 | 0.02 ▲   |
| US 5YR Bond  | 2.738 | 0.02 ▲   |
| US 10YR Bond | 2.860 | 0.04 ▲   |

### Валютын ханш /төг/

| Валют | 2018.08.31 | Өөрчлөлт |
|-------|------------|----------|
| USD   | 2,472.99   | 0.13% ▲  |
| CNY   | 361.99     | 0.88% ▲  |
| EUR   | 2,889.19   | 1.22% ▲  |
| RUB   | 36.36      | -0.19% ▼ |
| KRW   | 2.22       | 0.45% ▲  |
| JPY   | 22.32      | 0.68% ▲  |

### Түүхий эдийн үнэ

| Түүхий эд        | Хэмжих нэгж | Хаалт    | Өөрчлөлт |
|------------------|-------------|----------|----------|
| Алт /spot/       | USD/t oz.   | 1,198.13 | -0.60% ▼ |
| Мөнгө /spot/     | USD/t oz.   | 14.49    | -2.23% ▼ |
| Зэс              | USD/lb.     | 266.70   | -2.06% ▼ |
| Нүүрс            | USD/MT      | 110.15   | 2.94% ▲  |
| WTI газрын тос   | USD/bbl.    | 69.84    | 1.63% ▲  |
| Brent газрын тос | USD/bbl.    | 77.62    | 2.37% ▲  |
| Байгалийн хий    | USD/MMBtu   | 2.90     | -0.68% ▼ |

### Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

| Үзүүлэлт                         | Хугацаа   | Хэмжээ |
|----------------------------------|-----------|--------|
| Инфляцийн түвшин                 | 2018. VII | 7.70%  |
| Бодлогын хүү                     | 2018. VII | 10.00% |
| Банк хоорондын зах зээлийн хүү   | 2018. VI  | 10.00% |
| Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/ | 2018. VI  | 12.30% |
| Хадгаламжийн дундаж хүү /валют/  | 2018. VI  | 5.20%  |
| Зээлийн дундаж хүү /төгрөг/      | 2018. VI  | 18.00% |
| Зээлийн дундаж хүү /валют/       | 2018. VI  | 10.20% |

**Эх сурвалж:** Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 39 компанийн 724.4 сая төгрөгийн 3,117,649 ширхэг хувьцаа арилжигдав.


“Говь” /GOV/ компанийн хувьцаа 23.95%-аар буюу хамгийн ихээр өсч 30,840 төгрөгт хүрч хаагдсан бол “Хар тарвагатай” /TVT/ компанийн хувьцаа 15.00%-аар буурч 8,925 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны зах зээл дээр нийт 201 ширхэг үнэт цаас 21.1 сая төгрөгөөр арилжаалагджээ.


8-р сарын 31-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,302.4 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,841.58 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 3.5%-аар өссөн байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Зах зээлийн хураангуй

| Хураангуй             | Үнийн дүн /сая төг/ |
|-----------------------|---------------------|
| Арилжигдсан үнийн дүн | 745.5               |
| Зах зээлийн үнэлгээ   | 2,302,390.3         |

## Зах зээлийн индекс

| Индекс        | Хаалт     | Өөрчлөлт |
|---------------|-----------|----------|
| MSE Top 20    | 19,841.58 | 3.5% ▲   |
| MSE I индекс  | 9,260.63  | -0.34% ▼ |
| MSE II индекс | 9,224.7   | -0.02% ▼ |

## Идэвхтэй арилжигдсан хувьцаа

| Компани           | Ширхэг    | Үнийн дүн /төг/ |
|-------------------|-----------|-----------------|
| Говь              | 6,489     | 208,007,940     |
| ЛэндМН ББСБ       | 2,358,498 | 158,507,661     |
| АПУ               | 239,866   | 138,925,403     |
| Монгол базальт    | 218,026   | 74,846,297      |
| Эрдэнэ ресурс     | 75,554    | 48,080,484      |
| девелопмент корп. |           |                 |

## Өсөлттэй хувьцаа

| Компани       | Хаалт /төг/ | Өөрчлөлт |
|---------------|-------------|----------|
| Говь          | 30,840.00   | 23.95% ▲ |
| Хөх ган       | 108.00      | 20.00% ▲ |
| Орхон хөгжил  | 216.20      | 15.00% ▲ |
| Нако түлш     | 172.50      | 15.00% ▲ |
| Монгол шуудан | 590.00      | 9.26% ▲  |

## Бууралттай хувьцаа

| Компани        | Хаалт /төг/ | Өөрчлөлт  |
|----------------|-------------|-----------|
| Хар тарвагатай | 8,925.00    | -15.00% ▼ |
| Таван Толгой   | 6,865.00    | -14.56% ▼ |
| Ремикон        | 35.01       | -12.48% ▼ |
| Стандарт ноос  | 400.00      | -11.11% ▼ |
| Багануур       | 1,770.00    | -9.18% ▼  |

## Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

| Компани                      | Арилжааны үнийн дүн /төг/ |
|------------------------------|---------------------------|
| Мирэ Эссет Секьюритис Монгол | 244,795,717               |
| Новел инвестмент             | 193,017,206               |
| Бумбат-Алтай                 | 159,992,351               |
| Голомт Капитал               | 157,651,206               |
| Гаули                        | 118,071,870               |

## Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

| Компани      | Хаалт /төг/ | ЗЗҮ /сая.төг/ |
|--------------|-------------|---------------|
| АПУ          | 571.32      | 607,988       |
| Таван толгой | 6,865.00    | 361,547       |
| Говь         | 30,840.00   | 240,587       |
| МИК          | 10,980.00   | 227,388       |
| Сүү          | 214.45      | 73,771        |

## ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

### ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

| № | Үнэт цаасны нэр | Арилжигдсан ширхэг | Үнийн дүн /төг/ | Доод /төг/ | Дээд /төг/ | 7 хоног | Хүү |
|---|-----------------|--------------------|-----------------|------------|------------|---------|-----|
| - | -               | -                  | -               | -          | -          | -       | -   |

### ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

| № | Үнэт цаасны нэр               | Арилжигдсан ширхэг | Үнийн дүн /төг/ | Доод /төг/ | Дээд /төг/ | 7 хоног | Хүү     |
|---|-------------------------------|--------------------|-----------------|------------|------------|---------|---------|
| 1 | ZGEB-BD-09/05/19-A0242-15.995 | 201                | 21,147,210      | 105,210    | 105,210    | 104     | 15.995% |

## НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

| №  | Симбол | Компанийн нэр                            | Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/ | Нийт ногдол ашиг /сая төг/ | Шийдвэр огноо | Бүртгэлийн өдөр | Хуваарилах өдөр      |
|----|--------|--|----------------------------------|----------------------------|---------------|-----------------|----------------------|
| 1  | ERS    | Монгол алт                               | 150.00                           | 39.88                      | 2018.04.27    | 2018.04.05      | 2018.12.31-ний дотор |
| 2  | TEE    | Тээвэр дархан                            | 500.00                           | 81.67                      | 2018.04.27    | 2018.04.05      | 2018.12.31-ний дотор |
| 3  | TTL    | Таван Толгой                             | 2,410.00                         | 126,923.13                 | 2018.04.16    | 2018.04.03      | 2018.06.12-нд олгов  |
| 4  | EER    | Ариг гал                                 | 21.33                            | 74.21                      | 2018.04.25    | 2018.04.02      | 2018.09.01-с         |
| 5  | BDL    | Могойн гол                               | 100.00                           | 82.96                      | 2018.04.26    | 2018.01.18      | 2018.06.26-нд олгов  |
| 6  | DSS    | Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ | 56.60                            | 7.66                       | 2018.03.07    | 2018.03.27      | 2018.07.02-с         |
| 7  | TAL    | Талын гал                                | 50.00                            | 34.71                      | 2018.03.05    | 2018.04.26      | 2018.12.31-ний дотор |
| 8  | BRC    | Барилга корпораци                        | 700.00                           | 28.46                      | 2018.02.24    | 2018.03.16      | Тодорхойгүй          |
| 9  | AND    | Анд-Энерги                               | 1.27                             | 99.15                      | 2018.02.24    | 2018.03.16      | Тодорхойгүй          |
| 10 | SUL    | Жуулчин дюты фрий                        | 10,000.00                        | 653.62                     | 2018.02.23    | 2018.04.11      | 2018.05.01-с         |
| 11 | GTL    | Гутал                                    | 1,270.00                         | 83.01                      | 2018.02.19    | 2018.03.18      | 2018.07.06-с         |
| 12 | BNG    | Баянгол зочид буудал                     | 355.00                           | 150.19                     | 2018.02.19    | 2018.04.06      | 2018.09.01-с         |
| 13 | APU    | АПУ                                      | 10.00                            | 10,641.82                  | 2018.02.19    | 2018.03.29      | 2018.05.17-нд олгов  |
| 14 | BTG    | Баянтээг                                 | 100.00                           | 25.26                      | 2018.02.19    | 2018.03.12      | 2018.06.01-ний дотор |
| 15 | MIE    | Материалимпекс                           | 10.00                            | 13.68                      | 2018.02.19    | 2018.03.26      | 2018.04.17-нд олгов  |
| 16 | HRD    | Хүрд                                     | 497.00                           | 67.23                      | 2018.02.15    | 2018.02.23      | 2018.06.30-ны дотор  |
| 17 | SUU    | Сүү                                      | 3.00                             | 1,032.00                   | 2018.02.14    | 2018.04.05      | 2018.06.04-нд олгов  |
| 18 | MNP    | Монгол шуудан                            | 3.68                             | 366.48                     | 2018.02.13    | 2018.04.13      | 2018.06.05-нд олгов  |
| 19 | MMX    | Махимпекс                                | 100.00                           | 380.07                     | 2018.02.13    | 2018.04.05      | 2018.10.01-с         |
| 20 | TCK    | Талх чихэр                               | 170.00                           | 174.03                     | 2018.02.12    | 2018.04.06      | 2018.07.01-с         |
| 21 | GHC    | Ган Хийц                                 | 100.00                           | 24.25                      | 2018.02.09    | Тодорхойгүй     | Тодорхойгүй          |
| 22 | ADL    | Адуун чулуун                             | 130.00                           | 409.67                     | 2018.02.07    | 2018.03.01      | 2018.06.26-нд олгов  |
| 23 | TAH    | Тэхь-ко                                  | 108.00                           | 128.52                     | 2018.02.05    | 2018.03.30      | 2018.05.01-ний дотор |
| 24 | UBH    | Улаанбаатар хивс                         | 100.00                           | 40.48                      | 2018.02.05    | 2018.02.26      | 2018.05.01-с         |
| 25 | GOV    | Говь                                     | 220.00                           | 1,716.25                   | 2018.02.02    | 2018.03.27      | 2018.04.24-с олгов   |
| 26 | HRM    | Гермес центр                             | 5.00                             | 392.72                     | 2018.01.24    | 2018.02.15      | 2018.04.12-нд олгов  |



## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### СЗХ: “Ард даатгал” болон “Мандал даатгал”-д IPO гаргах зөвшөөрөл олголоо

Дотоодын хөрөнгийн зах зээлд шинээр дахин 2 компани IPO гаргах зөвшөөрлөө СЗХ-оос авлаа. Харин энэ удаа IPO гаргаж байгаа хоёр компани хоёулаа даатгалын салбарт үйл ажиллагаа явуулдаг гэдгээрээ онцлог болж байна. Ингэснээр 2018 он нь дотоодын хөрөнгийн зах зээлийн хувьд хамгийн олон IPO хийгдсэн жил болж байгаа гэдгээрээ анхаарал татаж байгаа юм. СЗХ-оос ийнхүү зөвшөөрлөө авснаар “Мандал даатгал” болон “Ард даатгал” компаниуд хөрөнгийн зах зээлд гарч ирж байгаа анхны даатгалын компаниуд болж байна.

МХБ-ээс “Ард даатгал” ХХК-ийн нэг бүр нь 200 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, нийт 25 сая ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлийн I ангилалд бүртгэсэн ба тус компанийн нийт гаргасан хувьцааны 30 хувь буюу 7.5 сая ширхэг хувьцааг нэг бүрийг нь 700 төгрөгийн тогтоосон үнээр олон нийтэд санал болгон худалдаалж, 5.25 тэрбум төгрөгийн санхүүжилт татан төвлөрүүлэхийг СЗХ-оос зөвшөөрсөн байна. “Ард даатгал” компани энэ оны эхний хагас жилд 163.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь жилийн дүнгээр гурав дахин өссөн үзүүлэлт болсон талаар Санхүүгийн Зохицуулах Хороо мэдээллээ. “Ард даатгал” компанийн андеррайтераар “Би Ди Сек” үнэт цаасны компани ажиллаж байна.

Дотоодын даатгалын салбарт нийт хөрөнгийн хэмжээгээрээ гуравдугаарт бичигддэг “Мандал даатгал” компани олон нийтээс 7.5 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхийг зорьжээ. МХБ-ээс “Мандал даатгал” ХХК-ийн нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 6,243,016 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлийн I ангилалд бүртгэж, тус компанийн нийт гаргасан хувьцааны 25 хувь буюу 1,560,754 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 4,800 төгрөгийн тогтоосон үнээр олон нийтэд санал болгон худалдаалж, нийт 7.5 тэрбум төгрөгийн санхүүжилт татан төвлөрүүлэхийг СЗХ-оос зөвшөөрсөн байна. “Мандал даатгал” компани энэ оны эхний хагас жилд 2.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өмнөх оны мөн үеэс 5.6 дахин өссөн дүн болжээ. Тус компанийн андеррайтераар нь “Голомт капитал” үнэт цаасны компани ажиллаж байна.

2018 оны эхний хагас жилд даатгалын салбарын нийт хөрөнгө 282.2 тэрбум төгрөг болж, жилийн дүнгээр 13.1 хувиар өсөөд байна. Мөн даатгалын компаниудын нийт хураамжийн орлого 84 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар буурчээ.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

### “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн хөрөнгө оруулагчдын анхааралд

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д бүртгэлтэй “Хөвсгөл Алтандуулга” ХК нийт 4.4 сая ширхэг буюу нийт хувьцааныхаа 28%-тай тэнцэх хувьцааг нэмж гаргах замаар 3,74 тэрбум төгрөг татан төвлөрүүлэхээр 2018 оны 8-р сарын 16-ны өдрийг хүртэл анхдагч зах зээлийн захиалгыг олон нийтээс болон стратегийн хөрөнгө оруулагчдаас хүлээн авсан билээ.

Захиалгын хугацаа дуусахад татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээ хангагдаагүй боловч гадаад, дотоодын стратегийн хөрөнгө оруулагч нараас тус үнэт цаасанд хөрөнгө оруулах саналыг шинээр ирүүлсэн тухай “Бумбат Алтай ҮЦК” ХХК-ийн албан хүсэлтийг харгалзан стратегийн хөрөнгө оруулагчдаас шаардлагатай хөрөнгийг 2018 оны 9-р сарын 10-ны өдрийн дотор татан төвлөрүүлж, анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсон талаарх тайланг ирүүлэхийг Санхүүгийн зохицуулах хорооноос “Бумбат Алтай ҮЦК” ХХК-д даалгасан байна.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

### СЗХ: “Зоос гоёл” ХК-ийн хувьцааг бүртгэлээс хаслаа

8-р сарын 29-ны өдрийн хуралдаанаар нийт хувьцааны 90.19 хувь төвлөрсөн “Зоос гоёл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийн хэлбэрийг өөрчилж, хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох тухай шийдвэрт үндэслэн тус компанийн нэг бүр нь 28,800 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 13,038 ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хаслаа. Үүнтэй холбогдуулан 5-аас бага хувийн хувьцаа эзэмшиж буй 369 хувьцаа эзэмшигчид оногдох ногдол хувийг нэгж хувьцаанд 289,440 төгрөгөөр тооцож авахыг компанид үүрэг болгож, ХХК-ийн хувьцаа эзэмшигчээр үлдэж болох эрхийг жижиг хувьцаа эзэмшигчдэд нээлттэй үлдээв.

**Эх сурвалж:** Санхүүгийн зохицуулах хороо

### “Говь” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Говь” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 26 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 10:00 цагт хуралдуулахаар болсон тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Бүртгэх өдөр: 2018.09.13-ны өдөр

Хуралдах газар: “Говь” ХК-ний Төв дэлгүүрийн дэргэдэх “Мираж” гэр ресторан

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн хувьцааг хуваах тухай асуудлыг хэлэлцэж батлах;
2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж, батлах.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

### “Хөсөг трейд” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Хөсөг трейд” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 4 тоот шийдвэрийн дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 10:00 цагт хуралдуулахаар боллоо.

Бүртгэх өдөр: 2018.09.13-ны өдөр

Хуралдах газар: Улаанбаатар хот, БГД 20-р хороо “Хөсөг трейд” ХК-ийн өөрийн байр

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Нэр бүхий хувьцаа эзэмшигчээс гаргасан хүсэлтийн дагуу хувьцааны өмчлөлийн бүртгэлд өөрчлөлт оруулах эсэх;
2. Бусад асуудал.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

### “Монинжбар” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Монинжбар” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 20 тоот тогтоолын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 15:00 цагт хуралдуулахаар боллоо.

Бүртгэх өдөр: 2018.09.03-ны өдөр

Хуралдах газар: Чингэлтэй Дүүрэг 6-р хороо, Бага тойруу 24/3 “Монинжбар” ХК-ийн өөрийн байр

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан;
2. Компанийн хэтийн зорилт, 2019 оны төлөвлөгөө;
3. ТУЗ – ийн ердийн болон хараат бус гишүүнд түр томилогдсон гишүүдийг баталгаажуулах;
4. Компанийн нэрийг өөрчлөх тухай.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### Гашуунсухайт боомтын дараалал буурав

Гашуунсухайт боомтод үүссэн дараалал багасаж байгаа гэдгийг “Гашуунсухайт авто зам” ХХК мэдээллээ. Пүрэв гарагийн байдлаар боомт дээр “Шалган 3”-аас хойш нүүрс ачсан автомашины цувааны урт 46 км болсон байна. Үүнээс гадна пүрэв гарагт Гашуунсухайт-Ганцмод боомтоор нийт 1026 автомашин нүүрс тээвэрлэн гарсан нь өмнөх өдрүүдийнхээс нэмэгджээ. Харин нүүрсний тээвэр хийж байгаа компаниудыг төлөөлж “Монгол тээвэр нэгдэл” компани хил дээр үүссэн дараалал зарим тохиолдолд 140 км хүрсэн талаар мэдээлсэн юм. 2018 он гарснаас хойш 4-6 дугаар сард Гашуунсухайт-Ганцмод боомтоор өдөрт дунджаар 850-950 тээврийн хэрэгсэл нэвтэрсэн талаар боомтын захиргаа мэдээлж байна. Монгол Улсын Засгийн газар өнгөрсөн зургаадугаар сард тогтоол гаргаж, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн уртын тээврийг эхлүүлсэн юм. Ингэснээр Тавантолгой-Цагаан хад-Гашуунсухайт, Тавантолгой-Гашуунсухайт гэсэн маршрутаар нүүрс тээвэрлэж байна. Энэ нь нүүрсний автомашинуудын тоо нэмэгдэхэд нөлөөлсөн гэж “Монгол тээвэр нэгдэл” ХХК онцоллоо. Мөн хил дээр үүссэн дараалал нь БНХАУ-ын талын нүүрсний татан авалтаас шууд хамаарч байгаа гэдгийг талууд онцолж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



### Монголбанк: 2018 онд алт худалдан авалтаа 10 хувиар өсгөж, 22 тоннд хүргэх зорилт тавьсан

Монголбанк 2018 онд худалдан авсан алтны хэмжээгээ 10 хувиар өсгөж, 22 тоннд хүргэх зорилт тавиад байна. Худалдан авах алтны хэмжээг 20 тонн хүргэхэд гадаад валютын албан нөөц 700 сая ам.доллараар нэмэгдэх боломжтой юм байна.

Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ сүүлийн жилүүдэд эрчимтэй өсөж байгаа аж. Энэ нь ашигт малтмалын нөөц ашигласны татварыг 2.5 хувь болгож бууруулсантай холбоотой гэж Монголбанк мэдээллээ. Татварын хөнгөлөлтийн хугацаа 2019 онд дуусна. Энэ хугацааг цаашид таван жилээр сунгах саналыг Монголбанкнаас Засгийн газарт хүргүүлээд байгаа ажээ.

Монголбанкнаас алт тушаалтыг нэмэгдүүлэх хүрээнд дэлхийн зах зээлийн ханшаар алт худалдан авч байна. Мөн Баянхонгор, Дархан-Уул аймагт сорьцын лаборатори байгуулахаар ажиллаж байна. Хэдий тийм боловч улсын алтны нөөцийг нэмэгдүүлэхэд хууль хяналтын байгууллагуудтай хамтран алтыг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэргийг бууруулахад анхаарах шаардлагатай байгааг Монголбанк онцоллоо.

2018 оны эхний найман сарын байдлаар 17.4 кг алтыг хууль бусаар хил нэвтрүүлэх гэж байсныг илрүүлэн улсын орлого болгосон байна. Статистикаас харвал 2010 оноос хойш нийт 204.5 кг алтыг энэ шалтгаанаар улсын орлого болгосон байдаг. “Алт-2” хөтөлбөрийн хүрээнд Засгийн газраас 2020 он гэхэд олборлолтыг 25 тоннд хүргэх зорилт тавиад байгаа юм. Гэхдээ энэхүү зорилтод хүрэхгүй болох эрсдэлтэйг ашигт малтмал, газрын тосны газраас онцолж байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

### Монголбанк: Шатахууны үнэ өмнөх оны мөн үеэс 250 орчим төгрөгөөр нэмэгдсэн

Монгол Улсын шатахууны импортын 90 орчим хувийг “Роснефть” компани нийлүүлдэг. Тус компанитай үнэ шинэчлэх яриа хэлэлцээг Засгийн газар ирэх оны гуравдугаар сард хийхээр товлож байгаа юм байна.

Монгол Улс оны эхний долоон сард 153 сая ам.долларын автобензин импортолсон нь жилийн өмнөхөөс 12 хувиар өссөн байна. Дизелийн түлшний импорт 316.8 сая ам.доллар болсон нь өмнөх оны мөн үеэс 25.5 хувиар өссөн байна. Ийнхүү шатахууны импорт мөнгөн дүнгээрээ огцом өссөн талаар Үндэсний статистикийн хороо мэдээллээ. Хэдий тийм боловч биет хэмжээгээр төдийлөн өөрчлөлт ороогүй байна. Оны эхний долоон сард автобензиний импорт таван хувиар буурч, 220.4 мянган тонн болсон бол дизелийн түлшний импорт 0.5 хувиар нэмэгдэж, 486.6 мянган тонн болжээ.

Дэлхийн зах зээл дэх нефтийн бүтээгдэхүүн болон Монголд импортолж байгаа шатахууны хилийн үнэ 40 орчим хувиар өссөнөөс хамаарч дотоодод шатахууны үнэ өнгөрсөн оны мөн үеэс 250 орчим төгрөгөөр нэмэгдсэн талаар Төв банк мэдээлсэн юм. Гэхдээ цаашид Засгийн газар татварын зохицуулалт хийхээр импортлогч компаниудтай ярилцаж, Олон Улсын Валютын Сантай зөвшилцсөний дараа Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэнэ гэж УУХҮ-ийн сайд Д.Сумъяабазар мэдэгдэж байв. Мөн ОХУ газрын тосны бүтээгдэхүүний экспортод татвар ногдуулахаар шийдвэрлэсэн нь Монгол Улсын шатахууны үнэд нөлөөлж магадгүй гэж эдийн засагч Н.Энхбаяр тайлбарлалаа.

Эх сурвалж: BloombergTv.mn



### ВІ: 2018-2020 онд мөнгөний эрэлт нэг оронтой тоогоор өсөх хүлээлттэй байна

“Bloomberg Intelligence”-ийн судалгаагаар мөнгөний эрэлт 2018-2020 онд нэг оронтой тоогоор өсөх хүлээлттэй байна. Нарны эрчим хүчний хавтан үйлдвэрлэлд ашиглах мөнгөний хэмжээ 22-37 хувиар нэмэгдэж, 27.9 сая унц хүртэлх хэмжээний металл шаардаж болзошгүй байгаа аж. Технологийн шинэчлэлтэй холбоотой ирэх гурван жилд нэг ватт эрчим хүч үйлдвэрлэхэд шаардах мөнгөний хэмжээ 6.2 хувь буурахаар тооцсон байна. Хэдий тийм боловч энэ хугацаанд дэлхийн хэмжээнд жилд шинээр суурилуулах нарны хавтангийн тоо 48-66 хувиар өсөх хүлээлттэй байна. Өсөлтөд сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйл нь мөнгийг орлох зэс, цайр зэрэг металлын хэрэглээ гэж дүгнэжээ. Үүний зэрэгцээ автомашинд мэдрэгч технологи суурилуулах болсон нь салбарын хэмжээнд мөнгөний хэрэглээг ирэх хоёр жилд 10 орчим хувиар өсгөхөөр байна.

Сүүлийн нэг жилийн хувьд мөнгө нь хамгийн тааруу үзүүлэлттэй металлын жагсаалтад багтаж байгаа юм. Ханш нь 18.7 хувиар унаж унц нь 14.7 ам.доллараар үнэлэгдэх болжээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

## БУСАД МЭДЭЭ

### Монголбанк: Валютын урсгал сайжирч байгаа нь ханш тогтвортой байхад нөлөөлж байна

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш сүүлийн хоёр сар харьцангуй тогтвортой байна. Учир нь Монгол Улсад орж, гарч байгаа валютын урсгал сайжирч, гадагшлах урсгал бага байгаа нь ханш тогтвортой байхад нөлөөлж байгааг Монголбанк мэдээллээ.

Мөн валютын захад дэд бүтцээс шалтгаалсан огцом хөдөлгөөн үүсэх нь буурсан гэдгийг Монголбанк онцолж байна. Төгрөгийн ханш цаашид тогтвортой байх хандлагатай байгааг СЭЗИС-ийн дэд профессор Ж.Дэлгэрсайхан онцоллоо.

Ханшид гол нөлөө үзүүлдэг төлбөрийн тэнцлийн статистикийг харвал оны эхнээс алдагдал нь 100 орчим сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал 1-р сард 233 сая ам.долларын алдагдалтай байсан төлбөрийн тэнцэл 5-р сард 201 сая ам.долларын ашигтай гарчээ. Харин 6-р сард 130 гаруй сая ам.долларын алдагдалтай гарсан байна. Үүнийг Монголбанк Монголоос гадагшлах валютын урсгал тийм ч их биш байгааг илтгэж байгаа тоон үзүүлэлт хэмээн тайлбарлав.

Ханшийн баталгааг хангах өөр нэг гол хүчин зүйл болох гадаад валютын албан нөөц 6-р сарын байдлаар 2.9 тэрбум ам.долларт хүрсэн байна. Энэ нь жилийн өмнөх мөн үеэс 2.5 дахин өссөн үзүүлэлт юм. Гадаад валютын албан нөөц өсөхөд алт худалдан авалтын хэмжээ, экспортын голлох бүтээгдэхүүний үнэ өссөн нь голчлон нөлөөлсөн байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### Монголбанк: Бизнесийн зээлийн өсөлт эрчимжиж байна

Бизнесийн зээлийн өсөлт сүүлийн хоёр сар эрчимжиж байгааг Монголбанк мэдээллээ. Жилийн дүнгээр бизнесийн зээл 15.7 хувиар өсөж, 7.8 их наяд төгрөгт хүрсэн байна. Хэдий тийм боловч хэрэглээний зээл 24.8 хувиар өссөн нь бизнесийн зээлийн өсөлтийг давсан үзүүлэлт юм.

Банкнүүдын зээлийн эх үүсвэр нэмэгдэх боломжтойг Төв банк онцолж байна. Учир нь хоёр их наяд гаруй төгрөгийн Төв банкны үнэт цаас гаргах боломжтой гэсэн мэдээлэл өглөө. Цаашид хэрэглээний зээлийг бизнест шилжүүлэх бодлого барьснаар 2019 он гэхэд бизнесийн зээл хангалттай хэмжээнд өснө гэж Монголбанк мэдээллээ.

Бизнесийн зээлийн өсөлт эрчимжиж байгаа нь эерэг үзүүлэлт боловч чанаргүй зээлийн түвшин өндөр хэвээр байна. Оны эхний долоон сарын байдлаар чанаргүй зээлийн хувь хэмжээ 8.6 хувь болсон байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар буурсан үзүүлэлт юм. Бизнесийн салбарын чанаргүй зээл нийт чанаргүй зээлийн 82 хувийг бүрдүүлж байгаа аж. Үүнээс боловсруулах үйлдвэрлэл, уул уурхай, барилгын салбарын чанаргүй зээл 50 гаруй хувийг дангаараа бүрдүүлжээ. Боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбарын чанаргүй зээл 2016 оны дунд үеэс огцом муудсан байдаг. Эдгээр салбарын чанаргүй зээл өмнөх оны мөн үеэс 50 орчим хувиар өссөн нь анхаарал татаж байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### Монголбанк: 2018 оны эцэст төлбөрийн тэнцэл 200-300 сая ам.долларын ашигтай гарах төлөвтэй байна

2018 оны сүүлийн хоёр улиралд Засгийн газарт хүлээгдэж буй томоохон өр төлбөр байхгүйг Монголбанк мэдээлж байна. Энэ нь гадаад валютын албан нөөцөд дарамт учруулахгүй, төгрөгийн ханш тогтвортой байх нэг хүчин зүйл болж байгааг Төв банк онцолж байгаа юм. Татварын орлого өсөж, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт эрчимжсэн 2018 онд Засгийн газар үндсэн төлбөрт 2.6 их наяд төгрөг, хүүгийн төлбөрт 1.2 их наяд төгрөг буюу нийт 3.8 их наяд төгрөгийн өр төлбөр барагдуулах шаардлагатай. Үүнээс 2.7 их наяд төгрөгийг оны эхний долоон сарын байдлаар төлж барагдуулаад байна. Оны эхний хагас жилд төлсөн өр төлбөр "Чингис" бонд, "Дим Сам" бондын төлбөрүүд багтаж байгаа юм.

Харин орох урсгалын хувьд Олон Улсын Валютын Сангийн "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд 2018 онд 836 сая ам.доллар Монгол Улсад үе шаттайгаар орж ирнэ. Энэ нь өнгөрсөн оноос 100 орчим сая ам.доллараар нэмэгдсэн үзүүлэлт юм.

Үүнээс гадна олон улсын байгууллага, донор орнуудын санхүүжилт болох 5.5 тэрбум ам.доллар "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн хүрээнд 2020 он хүртэл үе шаттайгаар орж ирэх юм.

Төв банкны мэдээлснээр төлбөрийн тэнцэл оны эцэст 200-300 сая ам.долларын ашигтай гарах төлөвтэй байна. Ингэснээр гадаад валютын албан нөөц энэ хэмжээгээр нэмэгдэх боломжтой ажээ. 2018 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2.9 тэрбум ам.долларт хүрсэн нь өнгөрсөн он мөн үеэс 2.5 дахин нэмэгдсэн үзүүлэлт болж байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### Импорт сүүлийн зургаан сар дараалан 40-өөс дээш хувиар өсөөд байна

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд өсөлттэй байгаа энэ үед импортын өсөлт сүүлийн зургаан сар дараалан 40-өөс дээш хувьд хадгалагдаж байна. 2018 оны эхний долоон сарын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 26 хувиар өсөж, 7.3 тэрбум ам.долларт хүрчээ.

Бараа эргэлтийн хэмжээ ийнхүү өсөхөд импорт 929 сая ам.доллараар буюу 40 хувиар өссөн нь голчлон нөлөөлжээ. Импортын өсөлтийг харвал хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний өсөлт 19 нэгж хувийг бүрдүүлж байгаа нь эдийн засгийг дэмжинэ гэж Монголбанк үзэж байна. Харин хэрэглээний бүтээгдэхүүний импортын өсөлт найман нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний импортын өсөлт долоон нэгж хувийг, аж үйлдвэрийн орцын импортын өсөлт зургаан нэгж хувийг бүрдүүлсэн байна. Газрын тосны ханшийн өсөлт үргэлжилж ирэх онд импортын өсөлт 30-40 хувьд хадгалагдах төлөвтэй байгааг эдийн засагчид онцолж байгаа юм.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

## МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.